

Батлав: БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчны
бодлого зохицуулалтын газрын дарга

/ Б.Буяннэмэх/

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
“Эхлэл Ургац Энержи” ХХК-ийн захирал.



/Ю.Төмөрхүү/

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН НУТАГТ ОРШИХ УРД ТАРАГТ ГӨЛТГӨНИЙ ОРД 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-21268/
/ААН-ИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5353564/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБЗГ-ын мэргэжилтэн / /

Төлөвлөгөө гаргасан:

Байгаль орчны мэргэжилтэн

/Т.Октябрь/

ГАРЧИГ

1. ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	2
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	3
2.5.1. Төслийн хүчин чадал	4
2.5.2. Ашигт малтмал	5
2.5.3. Ордын нөөц.....	6
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	7
Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл	7
Хөрсөн бүрхэвч болон газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл	7
Ургамалжилт, ургамлын нөмрөгт үзүүлэх шууд сөрөг нөлөөлөл	7
Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл.....	7
Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл	8
Эрүүл ахуйн судалгаа.....	8
Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал	8
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
Техникийн нөхөн сэргээлт	13
Биологийн нөхөн сэргээлт	14
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	28
13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	31
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ.....	33
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	35
ХАВСРАЛТУУД	36

1. ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн нэр:	Урд тарагтын гөлтгөнийн ордыг ил аргаар ашиглах төсөл
Төслийн хүчин чадал:	Жилд 40.0 мянган тонн гөлтгөнө олборлох хүчин чадалтай
Байршил:	Дундговь аймгийн Дэлгэрхангай сум
Хаяг:	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол, 202-29
Хариуцах хүн:	Байгаль орчны мэргэжилтэн Т.Октябрь. Утас: 99045481
ААН-ийн нэр, батлуулсан огноо:	Тус төслийн БОННУ-г Байгаль орчны судалгаа, үнэлгээний “И ЭЧ ЭС ЭМ ХХК хийж гүйцэтгэсэн. 2019 он

Хүснэгт 1. Уулын ажлын төлөвлөгөө

УРД ТАРАГТЫН ГӨЛТГӨНИЙ ОРДЫН 2023 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ		
	Түүхий эд	Нийт
Уурхайгаас олборлох түүхий эд	Нийт гөлтгөнө, Эзэлхүүн мян.м ³	138.4
	Хөрс мян.м ³	62.4
	Техникийн нөхөн сэргээлт Талбай /га/ Эзэлхүүн /мян.м ³ /	0.5 20.0
	Шимт хөрс Талбай /га/ Эзэлхүүн /мян.м ³ /	0.0 0.0
	Нийт уулын цул /мян.м³/	200.8

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Төслийн нэр

Урд тарагтын гөлтгөнийн ордыг ил аргаар ашиглах

2.1. Төслийн зорилго

Төсөл хэрэгжүүлэгч "Эхлэл Ургац Энержи" ХХК нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Урд тарагтын гөлтгөнийн ордыг Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайлалтын үйл ажиллагаа явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөнд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

2.2. Төсөл хэрэгжүүлэгч

“Эхлэл ургац энержи” ХХК

Улсын бүрдгэлийн дугаар: 9011222037

РД: 5353564

2.3. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг


Хаяг: Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол, 202-29

Утас: 99109100, 91919100

2.4. Төслийн байршил

Урд тарагтын гөлтгөнийн орд нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун урд зүгт 450 км, Дэлгэрхангай сумын төвөөс баруун урагш 34 км-т тус тус байрлана. Дэд бүтцийн хувьд сул хөгжсөн ба Улаанбаатар - Өмнөговь чиглэлийн хатуу хучилттай авто замаас 120 км зайтай.

Урд тарагтын ордын MV-021268 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын кадастрын хэлтсийн даргын 2018 оны 12-р сарын 26-ны өдрийн 904 тоот шийдвэрээр 2019 оны 01-р сарын 11-ээс 2049 оны 01-р сарын 11-ний өдрийг хүртэл буюу 30 жилийн хугацаатайгаар “Эхлэл Ургац Энержи” ХХК-д олгосон байна. Уг зөвшөөрлийн талбай нь Дэлгэрхангай уул нэртэй газар 221.94 га талбайг хамарна.



Зураг 1. Төслийн байршил

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрөл бүхий талбайн өнцгүүдийн газар зүйн солбицлууд

№	Талбай	Уртраг	Өргөрөг
1	221.94 га	104° 28' 46.1"	45° 1' 51.5"
2		104° 33' 33"	45° 1' 51.5"
3		104° 33' 33"	44° 59' 1.52"
4		104° 28' 46.1"	44° 59' 1.52"

2.5.1. Төслийн хүчин чадал

Ордын хувьд 40 мян.тн цэвэр гөлтгөнө олборлох хүчин чадалтай ба ашиглалтын хугацаанд нийт 400.0 мян.тн гөлтгөнө олборлож, 620.9 мян.м3 хөрс хуулна.

Одын хэмжээнд цэвэр гөлтгөнийн нөөц нь /В+С/ зэргээр 858.361.42 тн, үүнээс бодитой /В/ зэрэглэлийн нөөц нь 771.391.08 тн, боломжтой /С/ нөөц нь 86.970.34 тн тус тус хамаарна.

Олборлосон цэвэр гөлтгөнийг өөрсдийн гадаад тээврийн шланзаар Хулд сум хүртэл 120 км зайд тээвэрлэн хүргэнэ. Хулд суманд гэрээт компанийн ачааны машинд SEM 660D маркийн дугуйт ачигчаар дахин ачилт хийж цементийн үйлдвэрүүдэд нийлүүлэхээр төлөвлөж байна.

2.5.2. Ашигт малтмал

Урд тарагт ордын орчимд Монгол орны гөлтгөнийн голлох нөөц бүхий Тарагт, Ширээ уул, Ширээгийн хөндий зэрэг гөлтгөнийн бүлэг ордууд, олон тооны илрэл байдаг.

Дээрх ордуудад “Талст гөлтгөнө”, “Тээлийн шонхор”, “Эрдэнэгипс”, “МакЦемент” зэрэг компаниуд ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшин, олборлолтын ажиллагаа явуулж байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед Тарагтын ордыг ашиглаж, Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн гөлтгөнийн хэрэгцээг хангаж байсан бөгөөд сүүлийн үед Ширээ уулын ордын хэсэгт “Түмэн-анд” ХХК, “Талст гөлтгөнө” ХХК компаниуд ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна. Ордын дүүрэгт мэдэгдэж байгаа хайгуулын ажил хийгдээгүй илрэлүүдээс Бор хошууны илрэл хамгийн хэтийн төлөв өндөр, нөөц ихтэй илрэл бөгөөд Дэлгэрхангай уулын өврийн энэхүү томоохон хөндийд цаашид ч гөлтгөнийн томоохон орд илрэлүүдийг шинээр нээн илрүүлэх бүрэн боломж бий.

Урд тарагт орд орчмын гөлтгөнийн орд, илрэлүүд нь гарал үүслийн хувьд дүүргийн палеогеографийн болон цаг уурын нөхцөлтэй нягт уялдаатай юм. Дээд палеоген буюу олигоцены /E3/ үед дүүрэг нь ихээхэн чийглэг уур амьсгалтай байсан бөгөөд нуурын сав газар өргөсөн тэлж, гидрогеографийн сүлжээ харьцангуй шигүү байсан байна. Палеогены төгсгөл үе хүртэл эх газрын хурдас нь гидрографийн сүлжээ болон нуурын сав газрын өөрчлөлтөд нөлөөлсөн цаг уурын тогтворгүй нөхцөл бүрэлдэн бий болжээ. Энэ үеэс хуурай уур амьсгал зонхилон, хурдас хуримтлал тогтворгүй болж, энэ нь өнөө үед чулуулгийн фацийн тод өөрчлөлтөөр илэрдэг.

Урд тарагт гөлтгөнийн орд нь давхарга хэлбэрийн тогтоцтой тунамал ордын төрөлд хамаардаг. Тэрээр цэвэр нуурын гаралтай бөгөөд багавтар хэмжээний давстай устай нуур цөл, хагас цөлийн нөхцөлд хатаж уурших үед хүхэр хүчилт кальцийн тунадас бууж бүрэлджээ. Хүхэр хүчлийн кальци нь усан санд анх бүрэлдэхдээ давс түүнд хуримтлагдаж эхлэх үеэс эхэлсэн бөгөөд хүхэр хүчлийн кальциас өөр давсны төрөл түүнд тогтоогдоогүй байна. Энэ нь уусмал дахь түүний агууламж зайлшгүй багасах хүртэл хэмжээнд хүрээгүй байгаагаар тайлбарлагддаг. Газрын гадарга дээрх хөрсний ус нь хуурай уур амьсгалын нөлөөгөөр түргэн хатахад, түүн дэх хүхэр хүчлийн кальцийн агууламж нэмэгдэн ханасан уусмал бий болдог. Үүний дараа агуулагч чулуулагт кальцийн сульфатын жижиг бичил талстууд бүрэлддэг бөгөөд энэ нь өнөө үед гөлтгөнийн давхарга үүсжээ.

Хүхэр хүчлийн кальцийн өндөр агууламж бүхий усан уусмалын циркуляцын үр дүнд гөлтгөнжсөн шавар болон элсэн чулууны ан цаваар нэвчилтийн гөлтгөнө буюу гөлтгөнийн нимгэн судлууд, өөрөөр хэлбэл үелэг тогтоцтой селенитүүд үүсжээ.

Мөн доод цэрдийн тэвшийн говь формац, дээд цэрдийн сайншанд формац, олигоцений ангилагдаагүй хурдаснуудын улаан өнгийн шавар нь барилгын материалын тоосгоны шавар, тэвшийн говь формацын хурдастай холбоотойгоор хүрэн нүүрс шинээр илрэх боломжтой бөгөөд тэр чиглэлээр эрэл, хайгуулын ажлыг цаашид анхаарах хэрэгтэй.

Тарагтын гөлтгөнийн орд болон түүний дүүрэг дэх эрэл-зураглал, хайгуулын ажлын үр дүнгийн тайланд К.П.Атабекьянц нар 1961 онд хайгуулын талбайн зүүн урд хэсэг “Участок-V” дугаартай сидеритын эрлийн хэсгийг ялгасан байдаг.

Тус сидеритын илрэл нь 2014 оны “УГЗ-200 Өмнөд Монгол-VI” 1:200 000 масштабтай геологийн иж бүрдэл зураг зохиох ажлаар Б.Нямаа, А.Амаржаргал нарын гүйцэтгэсэн буюу хамгийн сүүлийн үеийн геологийн судалгааны ажлаар тэмдэглэгдээгүй,

бидний хайгуулын ажлаар илрэл нь өнөөгийн түвшинд тогтоогдоогүй юм. Хайгуулын талбай орчимд сидертын илрэл цаашид тогтоогдох бүрэн боломжтой юм.

2.5.3. Ордын нөөц

Гөлтгөнөжсөн давхарга нь бараг хэвтээ, зүүн урагш 1-2° өнцгөөр аажим уналттай, тархалтын хувьд зүүн хойноос баруун урагш сунасан, дунджаар 400 х 700 м хэмжээтэй, зуувандуу давхарга хэлбэрийн биет үүсгэдэг. Ашигт давхаргын нийт зузаан 1.2-6.1 м, дунджаар 3.14 м, хучаасны дундаж зузаан 1.43 м байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл

Төсөл хэрэгжих бүсэд агаар бохирдуулах гол эх үүсвэрүүдэд нь дараах хүчин зүйлс орно. Үүнд:

- Уурхай дахь машин механизмын үүсгэж буй хөрсний тоос, ачих буулгах ажлын тоос
- Дотоод шаталтат хөдөлгүүрийн утаа Дээрх хорт хаягдлыг агаарт ялгаруулах явцыг бууруулах зорилгоор дээрх хорт бодисуудыг бага ялгаруулдаг техник, технологи ашиглах арга хэмжээ авна. Түүнчлэн уурхайн эргэн тойрон ногоон бүс байгуулж салхинд хийсэх сул шороог багасгана. Тоос шороог дарахын тулд байнгын усалгаа хийх хэрэгтэй.

Тоосжилт: Гөлтгөний ордод түүхий эд болох гөлтгөнийг уринш хийх, эцсийн бүтээгдэхүүнийг зөөвөрлөх үед болон олборлолтын үйл ажиллагаанаас үүдсэн тоосжилт үүснэ. Ил уурхайг ашиглах явцад хүнд даацын автомашин явах үед болон гөлтгөнийг ачиж буулгах, уринш хийх, шигших үед их хэмжээний тоос ойр орчиндоо тархах нөхцөлтэй байна. Ялангуяа хөрс хуурай, салхи ихтэй хаврын улиралд их тоос босож ойр хавийн агаар, хөрсийг бохирдуулах, улмаар хүн ам, мал сүрэгт сөргөөр нөлөөлөх болно.

Хөрсөн бүрхэвч болон газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Уурхайн ашиглалтын явцад ил уурхай, хөрсний овоолго, шимт хөрсний овоолго болон бусад барилга байгууламжид өртөх талбайн хэмжээ нийтдээ 26.63 га байна. Олборлолтод өртөх талбайн үржил шимт хөрсийг урьдчилан 0.3 м-ийн зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах бөгөөд ордын ашиглалтын явцад болон ашиглаж дууссаны дараагаар хийгдэх нөхөн сэргээлтэд ашиглана.

Ургамалжилт, ургамлын нөмрөгт үзүүлэх шууд сөрөг нөлөөлөл

Ордын зам, машин, хүний үйл ажиллагаанаас уг талбайнуудын ургамлын нөмрөг устах аюултай юм. Устах аюултай ургамлаас гаднах талбайн ургамлууд тоосжилт ба талхагдлаас шалтгаалж ургац бүтээмж доройтож, шарилж, лууль зэрэг ургамал нэмэгдэх сөрөг нөлөөтэй.

Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл

Урд тарагт гөлтгөний орд нь Онги-Таацын голын усны сав газрын захиргаанд хамаардаг. Хайгуулын талбай районы хэмжээнд гаргасан ихэнх уст цэгүүд болох худгууд нь бүгд хуурай голдирол бүхий хайрга хайрганцар, элс, шавар, шаварлаг элстэй аллювипролювийн гаралтай сэвсгэр хурдсанд ухаж гаргасан байдаг. Энэ хурдас нь районы газрын доорх усны гол эх үүсвэр болдог. Худгийн усны түвшин 0.5-1.0 м-ээс 2-3 м-т хур тунадасны хэмжээнээс хамааран хэлбэлздэг. Тарагт орчмын хурдгуудын уснаас дээж авах, шинжилгээний ажлыг 1950 оны Өмнөд Монголын экспедицийн судалгааны ажлаар хийсэн байдаг бөгөөд химийн шинжилгээний үр дүнгээс харахад дээрх хурдгуудын ус нь сул эрдэсэжсэн, зөөлөн чанартай, унданд хэрэглэх бүрэн боломжтой юм.

Урд тарагт орд дээр хийгдсэн хайгуулын ажлын үед хийгдсэн өрмийн цооногт уст үе тогтоогдоогүй нь ордыг ил аргаар олборлох, ашиглалтын нөхцөлд таатай, уул техникийн хүндрэл гарахгүй, карьерт гүний ус хуримтлагдахгүй байх сайн талтай. Харин олборлолтын үед бага хэмжээгээр хуримтлагдаж болох хур тунадасны усыг карьерын ёроолд ус зайлуулах суваг малтах замаар амархан зайлуулах боломжтой. Ашиглалт явуулахад үйлдвэрлэлийн хэрэгцээний ус шаардагдахгүй, түүхий эдийг зөөвөрлөн Улаанбаатар хот,

Өргөн сумын цементийн үйлдвэрт нийлүүлэх юм. Ордын нөхөн сэргээлт, тээвэрлэлт зэрэгт усны хэрэгцээ тийм ихгүй ч мод, бут сөөг тарих, цаашид гөлтгөнө чулууг цэврээр гаргах зэрэгт усны хэрэгцээ гарч болох юм.

Хайгуулын талбай орчимд байрлах гар худгууд 500-900 л/цаг ундаргатай тул ундны усыг хангах хүрэлцээ муу зэргээс хамаарч ашиглалт эхлэх үед ахуй, ундны хэрэгцээнд хэрэглэх усыг өөрийн ундны худаг гаргах эсвэл бусад эх үүсвэрээс татна.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Төслийн талбай орчимд тархсан хөхтөн амьтад болон шувуудад уурхайн үйл ажиллагааны үүдэлтэй сөрөг нөлөөлөл шууд тусах эрсдэлтэй. Үүнд: Төслийн талбай орчимд одоогын байдлаар тархсан зарим зүйлийн хөхтөн амьтад, шувууд болон сээр нуруугүйтэн, шувуудад ил уурхай ашиглалтын үед үүсэх тоосжилт, дуу чимээ болон амьдрах орчны алдагдал нь сөрөг нөлөө үзүүлнэ. Уурхайн үйл ажиллагааны улмаас тухайн орчны агаар, хөрс бохирдохын хэрээр ургамлан нөмрөгт тодорхой хэмжээний өөрчлөлт орж улмаар үүнтэй уялдан амьтны аймгийн зүйлийн бүрэлдэхүүн, тархац нутаг хумигдана. Хүнд машин, механизм, техникийн дуу, чимээ, шатах, тослох материалын үнэрээс болж амьтны аймгийн төлөөлөгчид дайжиж тухайн орчны биотопод өөрчлөлт орж улмаар экосистемд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Автомашингаар олон салаа зам гаргах нь хөрсний эвдрэлд оруулж, тоосжилт үүсгэх, ургамлан бүрхэвчийг талхигдалд оруулах үүний улмаас амьтны аймгийн төлөөлөгчид ялангуяа шавьж, хөрсний микроорганизмууд устах аюултай. Төслийн талбайгаас Дэлгэрхангай сумын төв хүрэх автозам нь Дэлгэрхангай уулыг дайран өнгөрч байгаа нь тус ууланд тархсан уулын хөхтөн амьтдын шилжилт хөдөлгөөн, нүүдлийг тасалдуулах сөрөг нөлөөтэй байна.

Эрүүл ахуйн судалгаа

Урд тарагтын гөлтгөнийн ордод нийт 26 хүн ажиллана. Голлох дуу чимээний эх үүсвэр нь төсөлд ашиглагдаж буй техник технологи, машин механизм байх бөгөөд техник технологи, машин механизмын дэргэд удаан хугацаагаар ажиллах үед дуу чимээний бохирдолд ордын ажилтнууд өртөх магадлалтай юм.

Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал

Хөдөлмөрийн нөхцөл гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг хэлнэ. Хөдөлмөрийн хэвийн нөхцөл гэж (MNS 4967:2000 хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, нэр томъёо, тодорхойлолт) үйлдвэрлэлийн орчны хүчин зүйлийн нөлөөлөл нь ажилтанд нөлөөлдөггүй буюу тэдгээрийн хэмжээ нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй нөхцөлийг хэлнэ. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл гэж (MNS 4967:2000) хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагын хүрээнд сөрөг нөлөөллийг нь арилгах боломжгүй, хөдөлмөрийн стандартад нийцээгүй нөхцөлийг хэлнэ. Хөдөлмөрийн нөхцөл, ялангуяа хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийг эрдэмтэд, судлаачид нэлээд олон янзаар ангилдаг бөгөөд Монгол улсын "MNS 5080:2001-хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ стандартаар тогтоогдсон хөдөлмөрийн нөхцөлийн хортой, аюултай байдлаас хамаарах ангиллыг авч үзье. Хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг дотор нь тохиромжтой нөхцөл, зөвшөөрөгдөх нөхцөл гэж хоёр ангилна. Хөдөлмөрийн тохиромжтой нөхцөл гэж хөдөлмөрлөх явцад ажилтны эрүүл мэнд нь хэвийн хадгалагдах ба хөдөлмөрлөх чадвар нь ямагт өндөр төвшинд байхаар зохион байгуулагдсан

ажлын байрны орчинг ойлгоно. Үүнийг хөдөлмөрийн нөхцөлийн ангиллын "1 дүгээр анги" (цаашид "1" гэх) гэнэ. Үйлдвэрлэлийн хүчин зүйлийн тохиромжтой хэмжээг бичил уур амьсгалын үзүүлэлт болон хөдөлмөрийн үйл ажиллагааны зарим хүчин зүйлийн хувьд улсын стандартаар тогтоож өгсөн байдаг. Хөдөлмөрийн зөвшөөрөгдөх нөхцөл гэж хөдөлмөрлөх явцад ажлын байранд үүсч бий болсон буюу байсан үйлдвэрлэлийн хортой хүчин зүйлүүд нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй, ажилтны эрүүл мэнд, үр удамд цаашдын нөлөөгүй бөгөөд организмын үйл ажиллагаанд гарч болох өөрчлөлт нь дараагийн ажлын ээлж хүртэлх тогтоогдсон амралтын хугацаанд аяндаа сэргэх хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг хэлнэ. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийг үйлдвэрлэлийн орчны ба хөдөлмөрийн үйл ажиллагааны сөрөг хүчин зүйл нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан хэтрэлт, түүний улмаас ажилтны эрүүл мэндэд гарах өөрчлөлт болон хөдөлмөрийн чадвар буурах байдлаас хамааруулан хортой нөхцөл, аюултай нөхцөл гэж хоёр ангилна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ийг удирдлага болгов. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгахыг эрмэлзэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байх болно.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Урд тарагтын гөлтгөний MV-21268 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд нийт **долоон сая хоёр зуун мянга / 7 200 000/** зардлыг төсөвлөсөн.

Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	Төсөв /төгрөг/
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	820 000
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1 000 000
3.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3 000 000
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6.	Химий бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
7.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	540 000
8.	Болзошгүй осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	300 000
9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	540 000
10.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	500 000
11.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах хуваарь	500 000
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв		7 200 000

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ хэсэгт байгаль орчны судалгааны явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг оруулсан болно.

Хүснэгт 4. Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах ажлын төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Бууруулах арга хэмжээ	Цар хүрээ	Нэгжийн өртөг /мян. төг/	Нийт зардал /мян. төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ургамал болон хөрсөн бүрхэвч						
Төслийн үйл ажиллагаа эхлэсэнээр ургамлан нөмрөг антропоген нөлөөлөлд өртөх	Төслийн талбайн орчмын ургамлан нөмрөгийг хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулах, ажилчдад мэдээлэл өгөх	Төслийн хүрээнд	Нэг удаагийн сургалт 100.0	100.0	2023 он Жилд нэг удаа	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Уурхайн баян ахуйн үйл ажиллагаанаас хөрс бохирдох	Уурхайн баян ахуйн үйл ажиллагаанаас хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх бохирдсон тохиолдолд арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд		100.0	2023 он	Хог хаягдлын тухай хууль
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр хөрс талхагдах	Авто тээврийн хэрэгслийн сул хөдөлгөөнийг хязгаарлах, тогтсон маршрутын дагуу явах, технологийн замыг тэмдэгжүүлэх, өмнө жил байрлуулсан тэмдэг тэмдэглэгээ шинэчлэх засаж сайжируулах	Төслийн хүрээнд	Нэг тэмдэг хийлгэх өртөг- 30.0 төг 6 ш *30.0=180.0	180.0	2023 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, хөрс хамгаалах, цөлжилтөө сэргийлэх тухай хуулийн 7-р зүйлийн 7.1 заалт
Агаарын чанар						
Техник хэрэгслийн хөдөлгөөнөөр	Машин механизмуудын хөдөлгөөнөөр тоосжилт үүсэхээс сэргийлж технологийн зам дагуу	Технологийн зам дагуу	60.0	4 ширхэг х 60.0=240.0	жилд 1 удаа	Агаарын тухай хууль, MNS 4585:2007 агаарын чанар.

ажлын үр дүнд агаар орчны тоосжилт ү үч, орчны бохирдол ү үгэх	хурдны тэмдэг тэмдэглэгээ байрлуулах өмнө жил ашиглаж байсан тэмдэг тэмдэглэгээ солих засаж сайжируулах					Техникийн ерөнхий шаардлага ажлын байрны агаарын эрү ү ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3- 16:1998 MNS 5002:2000 хөдөлмөрийн аюулгүй шуугианы норм, аюулгүй ажиллагаа, эрү ү ахуй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 дуу чимээ-хэвийн норм, түвшний ХЭМЖЭЭ
<i>Амьтан</i>						
Дуу чимээ, техник хэрэгслийн хөдөлгө ө зэргээс ү дэн амьтад дайчих, тоо толгой багасах	Өвлийн хар зудтай жилү үдэд орон нутгийн байгаль орчны улсыг байцаагтай хамтран ан амьтдад өвс, мөс тавьж өгөх гэх мэт ажилд хамтран ажиллах	Орон нутгийн хэмжээнд	200.0	200.0	2023 он	Амьтны тухай хууль
<i>Нийт</i>			820 000			

Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал 820 000 төгрөг болж байна.

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын явцад ил уурхай, хөрсний овоолго, шимт хөрсний овоолгод өртөх талбайн хэмжээ нийтдээ 64.25 га байна. Олборлолтод өртөх талбайн үржил шимт хөрсийг урьдчилан 0.3 м-ийн зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах бөгөөд ордын ашиглалтын явцад болон ашиглаж дууссаны дараагаар хийгдэх нөхөн сэргээлтэнд ашиглана.

2023 онд олборлолтын үйл ажиллагаа шинээр ахилт хийгдэхгүй өмнөх оны шимт хөрс хуулсан талбайд олборлолт хийгдсэн.

Үржил шимт өнгөн хөрсийг хуулах, тээвэрлэх ажил: Тус уурхайн эдэлбэр газар орчмоос хуулах үржил шимт өнгөн хөрсний дундаж зузаан 0.3 м байна. Шимт хөрсийг дугуйт ачигчаар хуулж овоолго үүсгэн хураана. Энэхүү түр овоолгын өндөр 2-5м-ээс ихгүй, сул чөлөөтэй, ямар ч нягтаршуулалтгүй, овоолгын гадаргуу дээгүүр автосамосвал, дугуйт ачигч гэх мэт хүнд даацын тоног төхөөрөмж явахгүй байх шаардлагыг баримтална. Энэ ажлыг уурхайн инженер техникийн, ялангуяа технологи, маркшейдер инженерүүд жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөг зохиохдоо нарийвчлан тусгаж өгнө.

Нөхөн сэргээлтийн чиглэл болон гүйцэтгэх ажлууд

Уурхайн хаалтын үед нөхөн сэргээлтийн ажлыг малын бэлчээрийн чиглэлээр нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд 2023 онд 0.5 га талбайд 20000 м³ эзэлхүүнтэй техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэнэ. Энэхүү техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд дараагийн жилүүдэд биологийн нөхөн сэргээлт хийн ургамалжуулах байгалийн төрхөнд нь оруулах ажлууд хийгдэхээр төлөвлөж байна. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх үйл ажиллагаа нь 3 үндсэн үе шатаар хийгдэнэ.

1. Уул-техникийн нөхөн сэргээлт /овоолгыг хэвгийжүүлэх, хэлбэржүүлэх, шимт хөрсөөр бүрэх зэрэг ажлууд /
2. Биологийн нөхөн сэргээлт /Уул техникийн нөхөн сэргээлт хийгдэж дууссан газрыг ургамалжуулж ажлыг эхлүүлэх, хөрсийг бордох, сайжруулах, арчлах, тордох талаар тусгагдсан ажлууд хийгдэнэ./
3. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн дараах Мониторинг

Урд тарагтын гөлтгөнийн ордыг ашиглаж дууссаны дараа ил уурхайн дээд мөргөцгөөс 5 метрийн зайд 2.5 метрээс багагүй өндөртэй хашлага барьж, мөн хүн, авто тээврийн хэрэгсэл зайлшгүй явах замын ойролцоо хэсэгт анхааруулах тэмдэг хадсан байна. Түүнчлэн хөрсний овоолгын хажуугийн налууг 18 градус хүртэл хэвгийжүүлж хүн болон мал, амьтан явахад хүндрэлгүй болгоно. Хөрсний овоолго, гадаад болон дотоод тээврийн зам, ажилчдын хотхонд шимт хөрсийг 0.3 метрийн зузаантай тараан байрлуулж биологийн нөхөн сэргээлтийн ажилд бэлтгэнэ. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх техникийн үе шатанд дараах үндсэн ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Уул уурхайн үйл ажиллагаанд өртөж, нөхөн сэргээхээр төлөвлөж буй талбайг овор хэмжээ ихтэй чулуулаг, хог хаягдал, үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан байгууламжуудаас чөлөөлж, гарсан хог хаягдлыг зөвшөөрөгдсөн газарт зайлуулах;

- Талбайд үүссэн овон товон гадаргууг сийрүүлэн тэгшлэх, налуу гадаргууг орчных нь гадаргуугийн хэлбэр төрхтэй ойртуулан хэлбэршүүлэх, тогтворжуулах, оройг нь намсгах;
- Ус татах болон ус зайлуулах шугам хоолой байрлуулсан газар, далан, суваг шуудууг булж тэгшлэх, дэнжилсэн хана мөргөцгийг налуулах, эцэст нь нарийвчилсан тэгшилгээ, хэлбэршүүлэлт хийх;
- Нөхөн сэргээлт хийж буй гадаргууг эхлээд шимлэг хурдсаар, дараа нь ургамлын үндэс бүхий давхарга үүсгэх зорилгоор шимт хөрсөөр хучих;
- Уурхайн зориулалтаар Ыхийсэн шороон хаалт, далан, овоолгыг хэвгийжүүлэх, хэлбэршүүлэх замаар нөхөн сэргээх;
- Шаардлагатай тохиолдолд биологийн нөхөн сэргээлтэд тохирохгүй хөрс чулуулгийг эхлээд халхавч давхаргаар, дараа нь шимт хөрсөөр хучих;

Биологийн нөхөн сэргээлт

Нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны техникийн үе шат бүрэн дуусаж, овоолгын болон талбайн хөрс чулуулаг тогтворжиж, нягтарсны дараа овоолгод хадгалж байсан шимт хөрсийг эргүүлэн байршуулах замаар эвдэрсэн газрын биологийн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлнэ. Нөхөн сэргээлтийн биологийн үе шатанд гүйцэтгэх үйл ажиллагааны үндсэн чиглэл нь малын бэлчээрийн чиглэл байх бөгөөд тухайн бүс нутгийн онцлогт тохирсон ургамлын төрөл зүйлийг тарьж ургуулж арчлах замаар үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед элэгдэж, эвдэрсэн газрыг нөхөн сэргээж, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх явдал юм.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг олборлолтын ажил эхлэхийн өмнө уурхайн эдэлбэрийн байгаль орчны суурь нөхцөл байдлыг тодорхойлох урьдчилсан судалгаа явуулах, дараа нь уг судалгааны үр дүн болон бусад мэдээ, мэдээлэлд үндэслэн ургамалжуулах ажлын чиглэлийг тогтоох, эцэст нь техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд шимт хөрсний үе үүсгэн ургамалжуулалтыг байгалийн аясаар болон зохиомлоор тарьж ургуулах гэсэн дэс дараалалтайгаар гүйцэтгэнэ. Биологийн нөхөн сэргээлтийн үед сонгон авсан ургамлын төрөлд тохируулан хөрсийг сайжруулах, тухайн орон нутгийн нөхцөлд илүү зохицсон бутлаг ба модлог ургамлууд тарих нь илүү үр дүнтэй. Ургамалжуулалтад арчилгаа бага шаардах, зардал хямдтай олон наст ургамал болох ерхөг, согооврын үрийг суулгах нь түргэн нөхөн сэргээлтийг түргэсгэнэ. Хөрсний шинж чанар шаардлага хангахгүй тохиолдолд хөрс сайжруулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хэрэв хөрс хэт хүчиллэг юм уу шүлтлэг байвал саармагжуулах шаардлагатай.

Хөрсний нягт 2.2-2.7 г/см³ байвал зохистой бөгөөд нягт нь 3.0 г/см³-ээс дээш байвал хөрсийг сийрэгжүүлэх арга хэмжээ авна. Хөрсний шимт чанарыг нэмэгдүүлэх, ургамлын ургах нөхцөлийг хангахын тулд төрөл бүрийн бордоо хэрэглэдэг. Техникийн нөхөн сэргээлтийн дараа нөхөн сэргээж буй хөрсний агротехникийн шинж чанарт тохируулан мод, бут, ургамлыг нөхөн сэргээлтийн стандартын дагуу сонгож тариална. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008 стандартыг баримтална.

Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн ажлын зардлын тооцоо

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, /мян. төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Техникийн нөхөн сэргээлт					
Лицензийн талбайд олборлолт явуулж эхлэхээс өмнөх байгалийн унаган төрхөнд ойртуулан хүн мал амьтанд аюулгүй ландшафт бий болгох	Уурхайн ашиглалтын явцад ашиглагдсан орон зайг дотоод овоолгоор дүүргэж явах	2023 онд техникийн нөхөн сэргээлтийг Талбай – 0.5 га Эзэлхүүн – 20000 м ³	Уулын ажлын зардалд хамаарна	2023 он	<ul style="list-style-type: none"> • Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5914:2008 • Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008 • Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт, хийх аргачлал, 2009 он • Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS:5914:2008 • Ухсан газар, түр зуурын овоолго, үржил шимт хөрсийг хуулах шаардлага. MNS5916:2008
Уурхайн кемп	Уурхайн кемпийг төлөвлөлтэйгээр тохижуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.	Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд онд Уурхайн кемпийн тохижилтонд 30 ширхэг хайлаас модыг тарихаар төлөвлөж байна.	30 ширхэг х 5.0 = 150.0		
Дэлгэрхангай сум Тарагт худаг	Дэлгэрхангай сумын ЗДТГ-тай хамтран мод тарих үйл ажиллагааг хамтран зохион байгуулах	170 ширхэг хайлаас мод тарих	170 ширхэг х 5.0 = 850.0		
Нийт			1000.0		

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ


БОАЖЯ-наас төсөл хэрэгжүүлэгчийг Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаардсан тохиолдолд “Дүйцүүлэн хамгаалал хийх ажлын төлөвлөгөө”-г тусад нь тайлан болгон боловсруулж ажиллахыг санал болгож байна. Мөн жил бүр төсөл хэрэгжих орон нутгийн санал авч дүйцүүлэн хамгааллын талаар тохиролцон хамтран төлөвлөгөө гарган бүтээлчээр ажиллаж болох юм. Уурхай нь 10 жилийн дараагаар бүрэн хаагдаж, уурхайн ухшийг нөхөн дүүргэж, налууг хэвгийжүүлэн, биологийн нөхөн сэргээлт хийх тул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн нөхөн сэргээгдэх боломжгүй газар үлдэхгүй. Харин тоосжилтын тархалтын нөлөө, дуу чимээний бохирдол, газрын хэвлийн өөрчлөлт, эвдрэл зэргээс үүдсэн зарим амьтан ургамал устаж, дайжсан байх магадлалтай ба уурхай нь хэдийгээр нөхөн сэргээлт хийж, талбайг бүрэн ургамалжуулах ч байгалийн өөрийн аясаар бүрэлдсэн экосистемийг гүйцэхгүй. Иймд энэ хэмжээний хохирлыг тооцох боломжгүй байгаа тул дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Иймд компанийн нийгмийн хариуцлага болон дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд орон нутгийн төр захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэнд дүйцүүлэн хамгаалах зарчимд нийцсэн газарт нөхөн сэргээлтийн ажлыг хийж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино. Дүйцүүлэн хамгаалах ажилд шаардлагатай зардлыг тооцоолход нэг жилд 3 000 000 төгрөг болно.

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд ургамал тарималжуулахаас гадна тус тусгай зөвшөөрлийн орчим олборлолт явуулчаад нөхөн сэргээлт хийхгүйгээр хаяж явсан талбайнууд байдаг бөгөөд тухайн эвдэрсэн газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг санал болгож байна.

Мөн дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд БОАЖ, ШУА, Ургамлын аймаг ангилалзүйн лаборатори, ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн нарын 2018 онд гаргасан Монгол орны тарималжуулах шаардлагатай ургамлын төрөл зүйлүүд (зөвлөмж)-өөс дараах ургамлуудыг тарималжуулахыг зөвлөж байна. Үүнд: Өмхий шимэлдэг-*Dracoscephalum foetidum*, Зүүнгарын гоёо-*Cynomorium songaricum*, Зэлэн зангуу-*Tribulus terrestris* гэх ургамлыг тарималжуулах ажлыг санал болгосон.

2023 онд Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ЗДТГ-аас өгсөн чиглэлийн дагуу багийн төвийн гоожуурын худгийг мал, ан амьтан ундаалахад тохиромжтой болгон тохижуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.


**ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГА**


Чагдаржав 3-305 тоот, 4 дүгээр баг, Дэлгэрхангай сум,
Дундговь аймаг, 48170, Утас: (976) 7507 5959,
Цахим шуудан: delgerkhantai@dundgovi.gov.mn,
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2023.01.25 № 46

танай _____-ны № _____-т

“ЭХЛЭЛ УРГАЦ ЭНЕРЖИ” ХХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ю.ТӨМӨРХҮҮ ТАНАА

Тус сумын 2 дугаар багийн нутагт танай “УРД ТАРАГТ” нэртэй MV-021268 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд 2023 онд үйл ажиллагаа явуулахдаа Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Дүйцүүлэн хамгаалах ажлын жагсаалтад хуучин Тарагтын гоожуурын худаг түшиглэн мал, ан амьтан ундаалах цөөрөм байгуулах, мод тарьж ногоон зурвас байгуулах эх үүсвэр тавих, Дэлгэрхангай уулын орчимд булаг түшиглэн ховор ан амьтан ундаалах цөөрөм 1-ийг байгуулах ажлыг хамтран хийх санал хүргүүлж байна.


ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ *Ц. Дэлгэрсайхан* Ц.ДЭЛГЭРСАЙХАН

Зураг 2. Дүйцүүлэн хамгаалх арга хэмжээнийх хүсэлт

Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах ажлын зардлын тооцоо

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Тарагт гоожуурын худаг түшиглэн мал, ан амьтан ундаалах цөөрөм байгуулах	Ногоон байгууламж бий болгох	Дэлгэрхангай сум 3-р баг			3000.0	Жил бүр	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 3.1.11.“биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг.
Нийт дүн						3000.0		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гомдол, санал хүсэлтийг барагдуулах механизм:

Гомдол барагдуулах механизмын бүтэц, зохион байгуулалтыг загварчлахдаа дараах зарчмыг баримтлах ёстой. Үүнд:

- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр дээр орших үйлдвэрийн ажиллагсад, оршин суугчдын гомдол хүсэлт бүрийг бүртгэн хүлээн авч, хүлээн авч байгаагаар эргэж мэдэгдэх бүртгэлийн ил тод системийг бий болгосон байх
- Гомдол хүсэлт бүр нь тухайн төслийн хамрах хүрээнд багтаж буй эсэх, гомдол нь үндэслэлтэй эсэхийг тогтоох
- Гомдолд тусгасан асуудлыг судлах, үүний тулд ижил төстэй гомдлыг шийдэж байсан туршлагын талаар мэдээллийг цуглуулах, гомдлыг төслийн хүрээнд шийдэх боломжтой эсэх, боломжтой тохиолдолд барагдуулах ямар шийдлүүд байгааг бусадтай ярьж зөвшилцдөг байх
- Хөндлөнгийн зөвлөх, гуравдагч этгээдийн оролцоотой/оролцоогүйгээр шийдэх арга замууд:
 - Төслийн удирдлагын хүрээнд дотоод шийдвэр гаргах журмын дагуу, эсвэл тогтоосон дэг ёс, шалгуур үзүүлэлтээр тухайн гомдолд хариу өгөх, мөн гомдлыг шийдвэрлээгүй тохиолдолд төслийн дээд удирдах байгууллагад гомдлоо илгээх боломжийг олгох
 - Гомдол гаргагч болон төсөл хэрэгжүүлэгч нэгж хамтран ярилцах замаар шийдлийг олох
 - Сайн дурын үндсэн дээр зөвшилцөн шийд гаргаж чадаагүй тохиолдолд хөндлөнгийн этгээдийн өгсөн шийдлийн санал дээр үндэслэн гомдлыг шийдэх
- Гомдлын мөрөөр авсан шийдэл, арга хэмжээг хянах, хариу мэдэгдсэн эсэхийг нягтлан шалгах хяналтын бүтцийг бий болгох
- Төсөл хэрэгжүүлэх нэгж, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн ард иргэд, үйлдвэрийн газрын ажилтан, ажилчидтай гомдлын мөрөөр авч буй/авсан арга хэмжээний талаар мэдээлэл түгээх, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах талаар ард иргэдээс санал авах
- “Эхлэл Ургац Энержи”ХХК-ийн зөвшөөрлийн талбайд хамаарах Тарагт “ИХ” бууц нэртэй 000574828 тоот дугаартай Ө.Азжаргал иргэний өвөлжөөний газарт нөхөн олговор олгож нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг 2019-2020 онд авч хэрэгжүүлэн ажилласан. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээг дахин авч хэрэгжүүлэхгүй.

Хүснэгт 8. Нуулгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нуулгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян. төг/	Нийт зардал, /мян. төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1								
Нийт дүн						-		

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд археологи, палеонтологи, түүх соёлын дурсгалт зүйлс бүртгэгдээгүй болно.

Хүснэгт 9. Төслийн бүсэд түүх соёлын, шинжлэх ухааны дурсгалт зүйлс илэрсэн үед хамгаалах арга хэмжээ

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газрын хэвлийг хөндөхөд археологийн ба палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгал өртөж болзошгүй	Олдвор илэрвэл тухайн үед нь орон нутгийн захиргаанд мэдэгдэж холбогдох арга хэмжээ авах	Төслийн талбайд	-	Төсөв зохиож хэрэгжүүлэх	Шаардлагатай үед	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23.1, 27.8, 38.3 зэрэг заалтууд

10. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгана.

Уг төсөлд химийн бодис ашиглахгүй.

11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Санаатай болон санамсаргүй байдлаас гал гарах	Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах Жил бүр галын хорыг солих шаардлагагүй харин тухайн жилд 1 удаа цэнэглүүлнэ.	Уурхайн хэмжээнд	Галын хор 10 * 30.0 = 300.0	300.0	Төсөл хэрэгжихээс өмнө, үйл ажиллагааны явцад	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1 ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм
Ажилчдын аюулгүй байдлыг хангах	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагааны турш	
	Ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдол, аливаа гэмтэл ослыг бууруулах сургалт зохион байгуулах	Жил бүр	Үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр	
Гэнэтийн осол, гэмтэл, дэлбэрэлт	Барилга байгууламжийг газар хөдлөлийн бүсэд тохируулан хийцийг сонгох	Үйлдвэрийн барилгын ажлын үед	Үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагааны турш	
	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагааны турш	

	Байгаль орчин болон хөдөлмөр хамгааллын гэх мэт орон тооны мэргэжилтэн авч хариуцуулж ажиллуулах,	Үйл ажиллагааны турш		
Хүн, мал, амьтан, ургамлын гоц халдварт өвчин	Байгаль орчин болон хөдөлмөр хамгааллын гэх мэт орон тооны мэргэжилтэн авч хариуцуулж ажиллуулах, Төслийн хэмжээнд болон орон нутгийн хүн амд гамшгийн аюулын тухай дохио, сэрэмжлүүлэх мэдээлэл хүргэх, Гамшгаас хамгаалах арга хэмжээ авах, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, Орон нутгийн болон улсын онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах, Үйл ажиллагааныхаа онцлогт зохицуулан гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, алба, мэргэжлийн анги байгуулах,	Үйл ажиллагааны турш	ХАБЭА-н тухай хуулийн дагуу төслийн тухайн жилийн зардлын 1.5%-аас багагүй хөрөнгийг жил бүр төсөвлөх	Жил бүр
Хүчтэй цасан ба шороон шуурга				
Ган, зуд, цөлжилт				
Гал түймэр				
Газар хөдлөл				
Үер				
Аянга				
Хортон мэрэгчид тархах				
Нийт зардал			300.0	

Болзошгүй аюул, осолын нөлөөллийн зардал 300 000 төгрөг.

12. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.



Хатуу хог хаягдал-Ахуйн хог хаягдал, хаягдал мод төмөр, хуучин дугуй, сэлбэг хуванцар, гялгар, уут, гялгар баглаа боодол



Шингэн хаягдал-Ахуйн бохир ус, ашигласан тос, түлш шатахууны хаягдал



Хийн хаягдал-Хадгалах түлшний ууршилт машины ашиглалтаас үүсэх хий

Хатуу хог хаягдал: Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд ахуйн хэрэглээнээс гарсан хувинцар сав, шил, лааз, цаас, сав, баглаа боодол, асгарсан шатахуун, шатах тослох материалыг шингээж авсан цаас, алчуур, хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан зүйлс, техник тоног төхөөрөмжийн хаягдал сэлбэг хэрэгсэл (хаягдал төмөр, утас г.м) зэрэг зүйлс хатуу хог хаягдалд хамаарна. Төсөлд нийт 16 хүн ажиллах бөгөөд жилд 162 хоног өдөр ажиллана гэж тооцвол өдөрт 8 кг, сард 240 кг (16 хүн x 0.5 кг хатуу хог хаягдал/хоног x 30 хоног), жилд 1296 кг хог хаягдал гарах тооцоо байна. Энэ бол хүмүүсийн өдөр тутмын хэрэглээнээс гарах ахуйн хог хаягдлын тооцоо бөгөөд үүн дээр машин техникийн ШТМ, ашигласан тос маслын хаягдлыг тусгайлан хуримтлуулан 1 сард нэг удаа хаягдал тос, масло боловсруулах үйлвэрт гэрээ хийж тогтсон хугацаанд нийлүүлнэ.

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд үүсэх ахуйн хог хаягдлыг тусгай зориулалтын саванд ангилан ялгаж (дахин ашиглаж боломжтой эсхээр нь), хатуу хог хаягдалд зориулан барьсан хашаа, хайс хамгаалалттай цэг эсвэл байранд (мал, амьтан орхооргүй, хөрс, усанд шууд шингэх боломжгүй хатуу бетонон хучилтай байх) хадгалах шаардлагатай. бөгөөд Хонгор сумын засаг даргын тамгын газаргай байгуулсан гэрээний дагуу төвлөрсөн хогын цэгт зайлуулж булшлах шаардлагатай болно. Харин дахин ашиглаж боломжтой хуванцар сав, шил, лааз, цаас болон хаягдал төмрийг ялган цуглуулж, хоёр дахь түүхий эд боловсруулах үйлдвэрт тушаах нь зүйтэй.

Хатуу хог хаягдлыг эмх замбараагүй хаях, буруу хадгалж, зайлуулсны улмаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болох агаар, ус, хөрс, ургамлан нөмрөгг бохирдуулагч бодис тархаж, улмаар ажилчид болон төслийн талбай орчмын иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүйг онцгойлон анхаарах шаардлагатай.

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	2023 оны Хог хаягдлын гэрээг Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ЗДТГ-тай байгуулах	Ордын хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах		1	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэрэг 3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардалд тусгах		Төслийн хугацаанд	
	Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байх	Үйл ажиллагааны турш	80.0		Төслийн хугацаанд	
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж 1 тн хүрсэн тохиолдолд дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардалд тусгах		Төслийн хугацаанд	Нүхэн жорлон, угаадасны нүх, техникийн шаардлага MNS 5924:2015
	Бүх нийтийн цэвэрлэгээ хийх	Үйлдвэрийн анги орчимд	100.0		10 хоногт	
	Ариутгал, цэвэрлэгээг хийж 14 хоногт 1 удаа хийж гүйцэтгэх	Халуун ус, нийтийн бие засах газар	360.0		20 хоногт 1 удаа	
Хог, хаягдлын менежментийн нийт зардал			540.0			

Хог хаягдлын менежментийн нийт зардал 540 000 төгрөг болж байна.

13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (БОХШХ) нь төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон агуулахыг ашиглах явцад гарч болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм. Хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөх орчин тус бүрийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. БОХШХ-ийг хэрэгжүүлэхдээ энд заагдсан бохирдуулах эх үүсвэрүүдийг хянах Монгол Улсын хууль тогтоомж, стандартчилагдсан арга зүйн хязгааруудыг баримтлах шаардлагатай ба дээрх эрх зүйн актууд, стандартууд шинэчлэгдвэл түүний шинэчилсэн хувилбарыг мөрдөж ажиллах ёстой. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнг нь доорх асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

Анх таамагласан сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагавраас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар хир зөрж байгааг,

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг,

Нөлөөллүүдийн эрчим, буурах эсвэл ихэсч байгааг,

Төслийн БОХТ-ний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх, батлагдсан арга зүйг баримтлан стандартчилагдсан багаж, хэрэгслээр дээж, шинжилгээ хийх болон өгөгдлийг боловсруулах ажлыг төслийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтнууд удирдан явуулна. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсвийг тусгасан гүйцэтгэлийн менежментийн төлөвлөгөөг төслийн байгаль орчны асуудал хариуцсан зөвлөх болон ажилтнууд боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй. Цуглуулсан өгөгдлийг байгаль орчны асуудал хариуцсан ажилтан нэгтгэн, зохих анализыг хийж холбогдох газруудад мэдэгдэж байвал зохино. Гүйцэтгэлийн менежментийн үр дүнг цэвэршүүлсэн усны чанар, нийлүүлж буй ахуйн бохир ус, цэвэршүүлсэн бохир усны хэмжээний харьцаа, тоосжилтыг бууруулахад цэвэршүүлсэн газрын болон хөрсний чанар, тоосжилтыг бууруулах арга хэмжээ авахаас өмнөх агаар дахь тоосжилтын хэмжээ, арга хэмжээний дараах тоосжилтын хэмжээний харьцаа зэргээр үнэлнэ.

БОХШХ-ийн хэрэгжилт, үр дүн, түүнд хийсэн дүгнэлт зэргийг жил бүрийн 11-р сарын дотор тухайн орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд хүргүүлж хянуулан, дараа оны БОХШХ-ийг батлуулах ёстой. Хяналт шинжилгээний хөтөлбөрийг заавал тусгай эрхтэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж дүгнэлт гаргуулж байх шаардлагатай.

Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний зардал

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Х. Ш ажлын хэмжээ	Нэгжийн өртөг, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах стандарт ба арга аргачлал	Дээд, доод хязгаар
Агаарын чанар -Тоосжилт -Хорт хийнүүд NO2, SO2	мкг/м ³	Уурхайн карьер, уриншийн талбай, ШТС, кемп, ЗҮТ	Жилд 1 удаа	Нийт 4 дээж	35.0	140.0	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585 :2007 Агаар мандал. Сорьц авахад тавих үндсэн шаардлага MNS 3384-82 Хөдөлмөрийн нөхцөл хүчин зүйлийн ангилал, тодорхойлолт, үнэлэх шалгуур нөхцөл тогтоох аргачлал MNS 12.100-91	1 удаагийн хэмжилтээр: SO2 - 500 CO - 60000 Nox - 85 Тоос - 500
Дуу шуугианы түвшин	дБА	Уурхайн карьер, уриншийн талбай, ШТС, кемп, ЗҮТ	Жилд 1 удаа	Нийт 4 дээж	50.0	100.0	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585 :2007 Хөдөлмөр аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2000	Суурьшлын бүсрүү өдөр 60 дБА, шөнө 60 дБА хүртэл
Хөрсний чанар Ерөнхий үзүүлэлт, хүнд метал,	Сорьц шинжилгээ	Уурхайн карьер, уриншийн талбай, ШТС, кемп, ЗҮТ, шимт хөрсний овоолго	Жилд 1 удаа	Нийт 4 дээж	45.0	180.0	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2008 Шинжилгээнд сорьц авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298-91 Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох MNS 3310-91 БОХ. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл MNS 3985-87	MNS 5850 : 2008 стандартын хэм хэмжээнд

Хүснэгт 13. Усны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээний дээж	Байршил	Ажлын хэмжээ	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Баримтлах стандарт, аргачлал
Усны бүрэн шинжилгээ (Химийн үзүүлэлтүүд: Усны чанар рН хатуулаг, хуурай үлдэгдэл, хлорид, төмөр, нитрит, нитрат сульфат), хүнд метал, усны түвшин	Ус хангамжийн эх үүсвэр	Сорьц	Жилд 1 удаа	60.0	60.0	MNS 0900: 2005 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS4943: 2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага, MNS (ISO) 5667-10:2001 “Усны чанар.дээж авах. 10-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах заавар”.
Нян судлалын үзүүлэлт: Нянгийн тоо Гэдэсний бүлгийн савханцар Эмгэг төрөгч бактери Cl.perferringens	Ус хангамжийн эх үүсвэр	Сорьц	Жилд 1 удаа	60.0	60.0	

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал 540 000 төгрөг. Энэ зардалд зөвхөн шинжилгээний зардлууд багтсан бөгөөд мэргэжилтний болон бусад зардлууд ороогүй болно.

14. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

Эдэлбэр газрын болон үйл ажиллагаа явуулж буй хэсгээс дээжүүдийг авч шинжилгээнд хамруулж хяналт тавиж байх

Компанийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль журмын дагуу үйлдвэрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийлгэсэн дүнг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргэж тайлагнаж байна.

Орон нутгийн төр захиргааны болон бусад бусад байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг заасан цаг хугацаанд нь биелүүлэн чанд мөрдөж ажиллах шаардлагатай

Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах асуудлаар орон нутгийн төр захиргааны байгууллага болон эрх бүхий ажилтнуудтай байнга харилцан хамтарч ажиллах

Ерөнхий үнэлгээнд заасан чиглэл, болзлоос өөр үйл ажиллагаа явуулах болон үйлдвэрлэлийг өргөтгөх, тоног төхөөрөмжийг шинэчлэх бүрд ерөнхий үнэлгээнд хамрагдаж байх.

Хүснэгт:14 Удирдлага зохион байгуулалтын хэмжээнд хийгдэх ажлын төлөвлөгөө

Д/д	Төлөвлөсөн арга хэмжээ	Төсөв /мян.төг/	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцагч	Баримтлах хууль журам, стандарт	Тайлбар
			2023 он					
			4 сар	7-9 сар	5-9 сар			
1.	БОНБҮ болон БОХТ, ОХШХ-т заасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх	500.0	+	+	+	Ерөнхий инженер,	“Байгаль хамгаалах тухай” хууль	БОНБҮ, БОМТ, ОХШХ-г тусгагдсан үйл ажиллагаануудыг хийж гүйцэтгэх.
2.	Байгаль орчны холбогдолтой шинээр гарсан хууль, тогтоомж, стандартыг уурхайн удирдлагуудад танилцуулах		+			Байгаль орчны мэргэжилтэн		Холбогдох яамдын сургалт, хэлэлцүүлэгт тогтмол хамрагдах
3.	Байгаль орчин, нөхөн сэргээлтийн чиглэлээрх мэдээ, мэдээллээр самбаруудыг тогтмол шинэчлэж байх				+	Байгаль орчны хэсэг	“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10.1 – дэх заалт; БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 дүгээр тушаал	Нөхөн сэргээлт хийгдсэн талбай болон хийгдэж буй талбайн талаарх мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэж байх,
4.	Нийт ажилчдад байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлтийн чиглэлээр сургалт хийх		+	-	-			Тухайн жилийн БОМТөлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааны чиглэлийн дагуу сургалт хийх
Нийт төсөв		500.0						

Удирдлага зохион байгуулалтын зардалд 500 000 төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн.

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ

Байгаль хамгаалах төлөвлөгөөг төсөл хэрэгжих хугацааны туршид хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ дараах хувиарыг мөрдөх нь зүйтэй.

“Эхлэл ургац энерги” ХХК нь байгаль орчны төлөв байдалд хийсэн явцын хяналт шинжилгээг үндэслэн тухайн бодит нөхцөл байдалд нийцүүлэн төлөвлөгөөг жил бүр сайжруулан шинэчилж байх үүрэг хүлээнэ.

Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын байгаль орчны албатай нягт хамтран ажиллах ба төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар тогтоосон хугацаанд тайланг гаргаж мэдээлж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтэд төслийн баг байнга хяналт тавьж ажиллана.

Хүснэгт 15. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Төсөв /мян.төг/
Сумын иргэд, засаг дарга болон иргэдийн хурал	Тухайн жилийн сумын иргэдийн нийтийн хуралд үйл ажиллагаа танилцуулах	Үйл ажиллагаа болон БОМТөлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах	Жилд нэг удаа	Төслийн үйл ажиллагаатай холбоотой	Сумын холбогдох байгууллагатай тохиролцоно	500.0
Дундговь аймгийн БОАЖГ-т төлөвлөгөө танилцуулах	Батлагдсан төлөвлөгөө хэвэлмэл байдлаар хүргүүлэх	Тухан жилийн менежментийн төлөвлөгөө	Жилд нэг удаа	БОАЖГ-аас хийж гүйцэтгэх ажлын чиглэл авах	“Эхлэл ургац энерги” ХХК	
2023 оны байгаль орчны менежментийн	Тайлангийн дүгнүүлэх	2023 оны тайлан	2023 оны 11-р сарын 1	Аймгийн комиссоор хэлэлцүүлэх	БОАЖГ	

төлөвлөгөөний биелэлтийн тайлан	Тайлан батлуулах	2023 оны тайлан	2024 оны 2-р сарын 15-ны дотор	БОАЖЯ-ны ХБОБЗГ	
Нийт дүн					500.0

Олон нийтэд тайлагнах хуваарь төлөвлөгөөний зардалд 500 000 төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Төслийн Техник эдийн засгийн үндэслэл
2. Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээгээний дүгнэлт
3. Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээний тайлан
4. Төслийн 2023 оны уулын ажлын төлөвлөгөө
5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам / БОАЖЯ-ны сайдын 2019.10.29-ны өдрийн А-618 дугаар тушаал/
6. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал /БОАЖ-ын сайдын 2009.12.29-ний өдрийн 417 дугаар тушаал/
7. Байгаль орчин ногоон хөгжлийн яамны вэб сайт –www.met.gov.mn
8. Эрдэс баялаг, эрчим хүчний яамны вэб сайт – www.mmre.gov.mn
9. Ашигт малтмалын газрын вэб сайт – www.mrpam.gov.mn
10. Эрхзүйн мэдээллийн сайт – www.legalinfo.mn
11. Дундговь аймгийн вэб сайт – www.dundgovi.gov.mn

ХАВСРАЛТУУД

- Хавсралт 1.** Улсын бүртгэлийн гэрчилгээ
- Хавсралт 2.** Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл
- Хавсралт 3.** БОМТөлөвлөгөөний зураг
- Хавсралт 4.** Хяналтын хуудас
- Хавсралт 5.** Байгаль орчны барьцаа хөрөнгөний хуулбар
- Хавсралт 6.** 2023 оны Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний батлагдсан нүүр,
маягтууд